*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, бүртгэх, сангаас зарцуулалт хийх журам боловсруулах; | Боловсруулсан журмын төслийн тоо | ГБХНХ-ын сайдын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/106 дугаар тушаал батлагдсан. | 1 | Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын иргэн бүрд Хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Монголбанк, Эрдэнэс Монгол нэгдэл ХХК, Монголын ипотекийн корпораци, Санхүүгийн зохицуулах хороо, Зээлийн батлан даалтын сан зэрэг мэргэжлийн байгууллагуудаас 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1621 тоот албан бичгээр, 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/46 тоот албан бичгээр бүх яамдаас санал авч Засгийн газрын | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолын төсөл болон журмын төслийг боловсруулан холбогдох материалын хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Үндэсний орон сууцжуулалтын тогтолцоо, Хуримтлалын сангийн реформыг хэрэгжүүлэх хүрээнд Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, тогтолцооны шинэчлэлийг эхлүүлэх; | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд ээлэх хувь | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 179 дүгээр тогтоолоор Стратегийн ордуудын 34 хувьд ногдох ашиг 499.5 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлж, тус хөрөнгийг ипотекийн зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн. | 80% | Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэхээр заасан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 179 дүгээр тогтоолоор Стратегийн ордуудын 34 хувьд ногдох ашиг 499.5 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу Засгийн газар, Монголбанк хооронд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 81-0524/171 тоот “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г байгуулсан. Тус сангийн мөнгөн хөрөнгийг орон сууцны ипотекийн зээлийн эх үүсвэрт зориулж арилжааны 9 банканд хуваарилсан. Тус эх үүсвэрээр нийт 2681 иргэн ипотекийн зээлд | 2024.10-2024.12 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан. Үүнээс нийслэлд 1248, орон нутагт 1433 байна.<br>Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, тогтолцооны шинэчлэлийг эхлүүлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх талаар салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, нэгдсэн бодлого, шийдэл гаргах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолын 41 дүгээр хавсралтаар "Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталсан.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, хуримтлалын сангийн эх үүсвэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран ипотекийн зээлд нэн тэргүүнд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлсон мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор ажиллаж байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлэх; | Хамрагдсан даатгуулагчдын нийт тоо | 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг хуримтлуулж эхэлсэн. | 1.2 сая даатгуулагч | Нийгмийн даатгалын багц хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тэтгэврийн нөөц сангийн 2 хувийг мөнгөжүүлж, даатгуулагч бүрийг “Нийгмийн даатгал” аппликейшнээр дамжуулан “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал” бүртгэлийн данстай болгож, цахимаар шалгах боломжийг бүрдүүлсэн. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 1.1 сая даатгуулагчийн 214.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг бодитоор хуримтлуулаад байна. | 2024.10-2024.12 | 100% |
| 4. | Арга хэмжээ 1.4. Хуримтлалын сан, тэтгэврийн нөөц сангийн салбар дундын зохицуулалтыг хангах; | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | Монголбанк, Монголын Ипотекийн корпораци, Арилжааны банкуудын төлөөлөлтэй уулзалт зохион | 70% | Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, иргэдийг орон сууцжуулах асуудлаар салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Хот байгуулалт, барилга, орон | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулж "Хуримтлалын сан"-гийн мөнгөн хөрөнгийг ипотекийн зээлийн эх үүсвэр, орон сууцжуулалтад хэрхэн уялдуулах чиглэлээр санал солилцсон. | | сууцжуулалтын яам, Монголбанк, Монголын ипотекийн корпораци, Монголын банкны холбоо, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв, Нийслэлийн орон сууцны корпораци, Төрийн орон сууцны корпораци, Зээлийн батлан даалтын сан зэрэг холбогдох байгууллагууд хамтран “Хуримтлалын сан ба орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилт”-ийн талаар санал, загварын танилцуулгыг боловсруулж 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Ерөнхий сайдад танилцуулсан.<br>Орон сууцжуулалтын санхүүжилт, Хуримтлалын сангийн үйл ажиллагаа ба орон сууцжуулалтын талаарх нэгдсэн танилцуулга, мэдээллийг бэлтгэн Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны анхдугаар хурал, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконг хотод зохион байгуулагдсан “Дэлхийн тэтгэвэр, нийгмийн хамгаалал, үндэсний баялгийн сангийн дээд хэмжээний чуулга уулзалтад “Монгол Улсын орон сууцны цаашдын төлөв байдал - Орлогод нийцсэн хүртээмжтэй орон сууц” сэдэвт Олон Улсын форум, Монгол Улсын Ерөнхийлөгчийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ивээл дор зохион байгуулагдаж буй "Монгол Улс ногоон хөгжлийг санхүүжүүлэх нь" сэдэвт форум болон Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Европийн холбоо, Европын Комиссын Ази, номхон далайн бүс нутаг Ойрх Дорнодыг хариуцсан Олон Улсын түншлэлийн газар зэрэг олон улсын байгууллагуудтай хийсэн албаны уулзалт, Герман, БНХАУ зэрэг улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдуудтай хийсэн уулзалтуудад танилцуулга, мэдээлэл өгч ажилласан.<br>Орон сууцжуулах асуудлыг амжилттай хэрэгжүүлсэн улс орны туршлагыг судлах, орлогод нийцсэн, хүртээмжтэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх, ипотекийн зээлийг төрөлжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Дэлхийн банкны төслийн багтай хамтран ажиллаж Египет, Норвеги зэрэг улсын сайн туршлагыг судалсан. | | |
| 5. | Арга хэмжээ 1.5. Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санхүүгийн | Тооцоо судалгаа, мэдээлэл, баримт бичиг боловсруулсан хувь | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт | 80% | Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журам батлах | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслийг нэмэгдүүлэх талаарх боломжийг судлах; | | Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Банкны тухай хуулийн 3.1.20-д арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулж болно гэж тус тус заасан. | | тухай" 256 дугаар тогтоолыг батлуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор "нийслэлийн үнэт цаас" гэж нэмэлт оруулах боломжтой эсэх талаар судалж байна. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. Хуримтлалын сан, тэтгэврийн нөөц сангийн талаарх олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцжуулалттай уялдуулан хэрэгжүүлэх чиглэлээр (Монголбанк, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв, | 60% | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, баялгийн сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур улсад суугаа элчин сайдын яамтай хамтран тус улсын хөгжлийн сангууд, түүний удирдлага, менежментийг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай туршлага солилцох, албан уулзалт хийх | 2024.10-2024.12 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судлах, санал боловсруулах; | | Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, МИК, НОСК, ТОСК, ЗБДС, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, И-Монгол Академи) дэд ажлын хэсгийн уулзалт, хурлыг 5 удаа, Ерөнхий Сайдад танилцуулга мэдээлэл 1 удаа, Хуримтлалын сангийн үйл ажиллагаа ба орон сууцны тогтвортой санхүүжилт сэдвийн хүрээнд Дэлхийн банктай 3 удаа, ХААН банк, Голомт банкны | | ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Сингапур Улсад, “Сингапурын хамтын ажиллагаа”-ны байгууллагатай ажлын уулзалт хийсэн.<br>“Ази Номхон далайн хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааны байгууллага”-аас 2024 оны 11 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс Хонгконг-д зохион байгуулсан Дэлхийн тэтгэвэр, нийгмийн хамгаалал, Баялгийн сангийн дээд хэмжээний чуулга уулзалтад оролцож Тэтгэвэр, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын сан, Баялгийн сангийн чиглэлээр Засгийн газрын түвшинд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг олон улсын түвшинд сурталчлан таниулж, харилцан туршлага судалж, үндсэн илтгэгчээр оролцсон. Тус уулзалтын үеэр Хонгконгийн албан журмын хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын газартай тусгай сангуудын хөрөнгийн удирдлагын чиглэлээр туршлага судалж хамтран ажиллахаар харилцан тохиролцсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөөлөлтэй 1 удаа тус тус уулзалт, хурал зохион байгуулсан. | | | | |
| 7. | Арга хэмжээ 1.7. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Хуримтлалын санг орон сууцны санхүүжилттэй урт хугацаанд уялдуулах ажлын хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлсон судалгаа хийх; | Боловсруулсан тооцоо, судалгааны тоо | Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, хуримтлалын сангийн эх үүсвэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийсэн. | 2 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, хуримтлалын сангийн эх үүсвэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран ипотекийн зээлд нэн тэргүүнд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлох зорилгоор Өрхийн мэдээллийн сангийн 2023 оны мэдээлэлд үндэслэн иргэн, өрхийн орон сууцтай эсэх судалгааг 2023 оны байдлаар гаргасан. Зорилтот бүлэг тодорхойлсон судалгааны үр | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүнг Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв, Монголбанк зэрэг орон сууцжуулалтын чиглэлээр танилцуулга, мэдээлэл хийж ажиллаж буй мэргэжлийн байгууллагуудад цахимаар хүргүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны хуралд танилцуулсан. | | |
| 8. | Арга хэмжээ 1.8. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын иргэн бүрд Хуримтлалын нэрийн данс үүсгэх, мэдээлэл бүртгэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах; | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-нд батлагдаж, эрх зүйн орчин бүрдсэн. | 80% | Монгол Улсын иргэн бүрд Хуримтлалын нэрийн дансны бүртгэл үүсгэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн технологийн төв, Үндэсний Дата төв, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар зэрэг байгууллагуудад хамтран ажиллах албан бичгийг хүргүүлж, холбогдох уулзалтыг зохион байгуулж ажиллаж байна. Иргэн хуримтлалын нэрийн дансны мэдээллээ Төрийн мэдээллийн “ХУР”, И-Монгол цахим платформоор дамжуулан хэрхэн авах талаар, бүртгэлийн загварыг гарган 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/295 тоот албан | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1417 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүсэлт хүргүүлсэн. | | |
| **Зорилт 2. “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ” зорилтын хүрээнд”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор иргэд, олон нийтэд сурталчлан таниулах; | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 7 | Үндэсний орон сууцжуулалтын тогтолцоог Хуримтлалын сангийн санхүүжилттэй уялдуулан хэрэгжүүлэх хүрээнд ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх замаар, орлогод нийцсэн, хүртээмжтэй байдлаар орон сууцжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэх талаар олон улсын болон дотоодын хурал, форумд 8 удаа үндсэн илтгэгчээр оролцож олон нийтэд танилцуулга мэдээлэл хийсэн. | 2024.10-2024.12 | 70% |
| 2. | Арга хэмжээ 2.2. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох | Хамтран ажилласан байгууллагын тоо | Улсын бүртгэлийн ерөнхий газар, И-Монгол академи, Үндэсний дата төв, Монголбанк, | 5 | Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор Герман, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамд, Бүгд Найрамдах Сингапур Улсын “Сингапурын хамтын ажиллагаа”-ны байгууллага, Нэгдсэн Үндэстний | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах; | | Эрдэнэс Монгол ХХК болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | | Байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Европын холбоо, Европын Комиссын Ази, номхон далайн бүс нутаг Ойрх Дорнодыг хариуцсан Олон Улсын түншлэлийн газар зэрэг олон улсын байгууллагууд болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Монголбанк, Монголын ипотекийн корпораци, “Эрдэнэс Монгол нэгдэл” ХХК, Монголын банкны холбоо, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв, Нийслэлийн орон сууцны корпораци, Төрийн орон сууцны корпораци, Зээлийн батлан даалтын сан, Үнэт цаасны төвлөрсөн төв хадгаламжийн төв, Голомт банк, Хаанбанк, Худалдаа хөгжлийн банк, Санхүүгийн мэдээллийн технологийн төв, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний Дата төв зэрэг байгууллагууд тус тус хамтран ажилласан. | | |
| 3. | Арга хэмжээ 2.3. Удирдлагууд болон холбогдох байгууллагуудыг | Бэлтгэсэн мэдээллийн тоо | | 8 | Удирдлагууд болон холбогдох байгууллагуудыг цаг үеийн мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж ажилласан. | 2024.10-2024.12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх; | | | | | | |
| **Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах; | Боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. | 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | 2024.10-2024.12 | 100% |
| 2. | Арга хэмжээ 3.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх; | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн. | 1 | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн. | 2024.10-2024.12 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3.3. Дээд газар, холбогдох байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах; | Тогтоол, шийдвэрийн тоо | Ирсэн албан бичиг, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллаж байна. | 1 | Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 30 дугаар тогтоол, Засгийн газрын 179 дүгээр тогтоолын биелэлтийг хангаж ажиллаж байна. | 2024.10-2024.12 | 100% |

**Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Үндэсний баялгийн сан, Хуримтлалын сантай холбоотой хууль, тогтоомжийг судлах, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх; | Холбогдох баримт бичиг, судалгаа, тайлан судалсан эсэх (Тийм:1 / Үгүй:0) | Холбогдох баримт бичиг, судалгаа, тайланг тухай бүр судалсан | - | Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Хуримтлалын сантай холбоотой хууль, тогтоомжийг судлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2024.10-2024.12 | 100% |
| 2. | Арга хэмжээ 2. Бусад цаг үеийн сургалтад хамрагдан ур чадвараа дээшлүүлэх; | Хамрагдсан сургалтын тоо | | - | Байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн сургалтанд тухай бүр хамрагдсан. | 2024.10-2024.12 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга
( Албан тушаал )

А.Хишигбаяр /......................... /
( Нэр, гарын үсэг )

/ 2024.12.05 /
( Огноо )